



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА
ХОЛБООНЫ САЙД

Сүхбаатарын талбай 1, 1 дүгээр хороо, Чингэлтэй
дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 51-265102, Факс: 11-330780
Цахим шуудан: info@mddic.gov.mn
Цахим хуудас: www.mddic.gov.mn

2025.10.10 № 01/2348

танай 2025.10.08 -ны № 1/1621 -т

Г ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН Г
САЙД Л.МӨНХБААТАР ТАНАА

Танаас ирүүлсэн 2025 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 01/1621 дугаар албан бичигтэй танилцлаа. Уг албан бичигт дурдсаны дагуу захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй 29 шийдвэрийн талаарх тайлан мэдээ болон хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн хамт үүгээр хүргүүлж байна.



Цахим хөгжил, инновац, харилцаа
холбооны яам
Удирдлага
Сайд
Энхбаяр Батшугар
2025-10-10 19:26:27



**ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМ**

**ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙДЫН БАТАЛСАН
ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТАД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ТАЙЛАН, ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ**

**УЛААНБААТАР
2025 ОН**

“ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙДЫН БАТАЛСАН ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТАД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН,

2025 оны 10 дугаар сарын 10-ны өдөр

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, үндэслэл, арга зүй

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын баталсан захиргааны хэм хэмжээний актад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал гаргаж, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, журмын хэрэгжилтийг биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан “Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг удирдлага болгов.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын баталсан 29 захиргааны актад хяналт-шинжилгээ хийхдээ 6 нөхцөл байдлыг харгалзан үзлээ. Үүнд:

1. Тэмдэглэх хэсэгт үндэслэл болгосон эрх олгосон хуулийн заалтад өөрчлөлт орсон - 0 захиргааны акт
2. Журмын доторх үндэслэл болгож, эшлэл хийсэн хуулийн заалт бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа -26 захиргааны акт
3. Шинээр батлагдсан холбогдох хуультай нийцсэн-26 захиргааны акт
4. Бүртгэлтэй шийдвэрт нэмэлт, өөрчлөлт оруулсан, хүчингүй болгосон тухай бүрд нь санд холбогдох хөдөлгөөн хийлгэсэн—8 захиргааны акт
5. Ач холбогдлоо алдсан, дагаж мөрдөхгүй болсон шийдвэр байгаа бол хүчингүй болгон сангаас хасуулах арга хэмжээ авсан-0 захиргааны акт
6. Санд бүртгүүлээгүй -0 захиргааны акт тус тус байна.

Захиргааны актын хавсралтаар баталсан журмын доторх үндэслэл болгож, эшлэл хийсэн заалтууд болон бусад зохицуулалтууд нь шинээр батлагдсан холбогдох хууль тогтоомжтой нийцээгүй 3 захиргааны акт байна. Үүнд:

➤ Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2020 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн “Журам батлах тухай” А/55 дугаар тушаал./санд бүртгэгдсэн огноо дугаар: 2020.05.12 №4794/ Шуудангаар үйлчлэгч болон шуудангийн илгээмж тээвэрлэгч этгээдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах журмын хувьд өөрчлөлт орж байгаагүй бөгөөд цаашид тус журмын зохицуулалтыг хуульд тусгаж, журмыг хүчингүй болгохоор төслийг боловсруулж байна.

➤ Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2020 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” А/48 дугаар тушаалаар баталсан “Радио давтамжийн зурвасыг төлөвлөх, дахин төлөвлөх, хуваарилах, ашиглах журам”. Уг журмын хувьд Журмын 2.1-д заасан харилцаа холбооны асуудал хариуцсан төрийн захиргааны гэсний дараа “төв” гэж нэмэх, 5.2-г хасах шаардлагатай.

➤ Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн “Журам батлах тухай” А/116 дугаартай тушаалын хавсралтаар баталсан “Төрийн өмчийн радио, телевизийн газрын сүлжээгээр орон даяар болон тухайн орон

нутагт дамжуулах өргөн нэвтрүүлгийн радио, телевизийг сонгох шалгуур үзүүлэлт, тавигдах шаардлага”. Уг журмын 3.3-д заасан хуулийн эшлэлийг өөрчлөхөөр байна.

Түүнчлэн бүртгэлтэй шийдвэрт нэмэлт, өөрчлөлт оруулсан, хүчингүй болгосон, тухай бүрд нь санд холбогдох хөдөлгөөн хийлгэсэн дараах 8 захиргааны акт байна. Үүнд:

1. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2017 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн “Журам батлах тухай” А/42 дугаартай тушаалаар ХХМТГ-ын даргын 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/60 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсон.

2. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2020 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” А/47 дугаар тушаалаар ХХМТГ-ын даргын 2020 оны А/39 дүгээр тушаалыг хүчингүй болгосон.

3. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн “Журам батлах тухай” А/37 дугаар тушаалаар ХХМТГ-ын даргын 2020 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн А/44 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсон.

4. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2020 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” А/48 дугаар тушаалаар 2020 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн А/44 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсон.

5. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн “Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт батлах тухай” А/46 дугаар тушаалаар ХХМТГ-ын даргын 2020 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн А/80 дугаар тушаал, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн А/29 дугаар тушаал, 2023 оны 05 дугаар сарын 09-ны өдрийн А/42 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсон.

6. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2020 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн “Журам батлах тухай” А/47 дугаар тушаалаар ХХМТГ-ын даргын 2016 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/58 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсон.

7. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын хамтарсан 2022 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн “Зөвлөлийн ажиллах журам, бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” А/268, А/48 дугаар тушаалаар Хууль зүй, дотоод хэргийн сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын хамтарсан 2022 оны А/228/А/44 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсон.

8. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн “Журам батлах тухай” А/74 дүгээр тушаалаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны 07 дугаар сарын 06-ний өдрийн А/65 дугаар тушаал хүчингүй болсонд тус тус тооцсон байна.

Мөн Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал бүхий 12 захиргааны акт байна. Тухайлбал Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2017 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн “Журам батлах тухай” тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үзүүлэх зохицуулалтын үйлчилгээний хэмжээг тогтоох тухай А/42 дугаар тушаалын хувьд Журмын 5.1-д заасан “харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны” гэсний дараа “төв” гэж нэмэх;

Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн А/35 дугаар тушаалаар баталсан Төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллагаас үйлчилгээ үзүүлэх журамын хувьд зохицуулалтыг хуульд тусгаж, журмыг хүчингүй болгох төслийг боловсруулсан;

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2020 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн А/54 дүгээр тушаалаар баталсан Үнэ бүхий шуудангийн тэмдэгтийн үйлдвэрлэлт, дахин үнэлэлт, борлуулалтын журмын 2.1.1.4, 2.1.1.5, 2.1.2.1-д заасан “харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны” гэсний дараа “төв” гэж нэмэх, 3.4-д заасан “шуудангийн асуудал эрхэлсэн төрийн

захиргааны” гэснийг “харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв” гэж өөрчлөх;

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2020 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн А/53 дугаар тушаалаар баталсан шуудангийн үйлчилгээ үзүүлэхэд мөрдөх журмын зохицуулалтыг хуульд тусгаж, журмыг хүчингүй болгох төсөл боловсруулсан;

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2020 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн А/56 дугаар тушаалаар баталсан Шуудангийн илгээмжийг түр хадгалах, задлах, хураах болон устгах журмын 6.3-д заасан “харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны” гэсний дараа “төв” гэж нэмэх;

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2020 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн А/48 дугаар тушаалаар баталсан Радио давтамжийн зурвасыг төлөвлөх, дахин төлөвлөх, хуваарилах, ашиглах журмын 2.1-д заасан “харилцаа холбооны асуудал хариуцсан төрийн захиргааны” гэсний дараа “төв” гэж нэмэх, 5.2-г хасах;

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2020 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн А/47 дугаар тушаалаар баталсан Шуудангийн үйлчилгээ үзүүлэхэд мөрдөх журмын зохицуулалтыг хуульд тусгаж, журмыг хүчингүй болгохоор төслийг боловсруулсан;

Цахим хөгжил, харилцаа холбооны сайлын 2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн А/116 дугаар тушаалаар баталсан Төрийн өмчийн радио, телевизийн газрын сүлжээгээр орон даяар болон тухайн орон нутагт дамжуулах өргөн нэвтрүүлгийн радио, телевизийг сонгох шалгуур үзүүлэлт, тавигдах шаардлага бүхий журмын Журмын 3.3-д заасан хуулийн эшлэлийг өөрчлөх;

Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/18 дугаар тушаалаар баталсан Мэдээлэл хариуцагч нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө үйл ажиллагаанд зөвлөмж, дүгнэлт гаргах журмын зохицуулалтыг хуульд тусгаж, журмыг хүчингүй болгохоор төслийг боловсруулсан.

Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн А/28 дугаар тушаалаар баталсан Төрийн албан хаагчид тоон гарын үсгийн гэрчилгээ олгох, түүнийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох журмын 2.2, 2.3-т заасан ХУР системээс татаж шалгах боломжтой мэдээллийг хүн, хуулийн этгээдээс шаардахгүй байхаар өөрчлөлт оруулах;

Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн А/30 дугаар тушаалаар баталсан Тоон гарын үсгийн гэрчилгээний үндэсний санг бүрдүүлэх, ашиглах журмыг ХХЗХ-ны 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 53 дугаар тогтоолоор баталсан “Тоон гарын үсгийн гэрчилгээний мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах, хадгалах журам”-аар зохицуулсан харилцаа давхардсан байх тул эдгээр журмыг нэгтгэн батлах зохицуулалтыг хуульд тусгахаар тус тус санал боловсруулжээ.

Түүнчлэн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын баталсан 29 захиргааны хэм хэмжээний актад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дээрх нөхцөл байдлууд тогтоогдож байх бөгөөд зарим захиргааны актын хэрэгжилтийг нэмэлтээр судлан үзлээ. Үүнд:

1. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны А/28 дугаар тушаалаар баталсан Төрийн албан хаагчид тоон гарын үсгийн гэрчилгээ олгох, түүнийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох журмын хувьд Улсын бүртгэлийн ерөнхий газраас 2025 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 1,838,381 буюу Мон Пасс СА ХХК 92,020, Тридум кей ХХК 41,886, Нью компас ХХК 48,181, Ви Эс Эм ХХК 138, Үндэсний дата төв 14250, Улсын бүртгэлийн ерөнхий газар 1,641,906 иргэнд тоон гарын үсэг олгоод байна. 2025 оны 3 дугаар улирлын байдлаар Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын салбар Төрийн үйлчилгээний "ХУРДАН" цэгийг

нийслэл дэх 145, орон нутаг дахь 361 цэгээр дамжуулан нийт 46,275 иргэнд тоон гарын үсэг олгоод байна.

Мөн Төрийн үйлчилгээний ХУРДАН киоск машиныг нийслэлд 150, орон нутаг 332 буюу нийт 482 киоск машиныг байршуулан төрийн үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд хүндрэл чирэгдэлгүй үзүүлэх боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.

2. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны А/30 дугаар тушаалаар баталсан Тоон гарын үсгийн гэрчилгээний үндэсний санг бүрдүүлэх, ашиглах журмын хувьд И-Монгол академи УТҮГ болон Үндэсний дата төв УТҮГ нь гэрчилгээжүүлэх байгууллагаас бүрдүүлж, ашиглаж байгаа гэрчилгээний мэдээллийн санд тусгасан тоон гарын үсгийн гэрчилгээ олгосон, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон мэдээлэлд үндэслэн тоон гарын үсгийн гэрчилгээний үндэсний санг бүрдүүлэн тогтмол шинэчилэх ажиллагаанууд хийгдэж байна.

3. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны А/74 дүгээр тушаалаар баталсан Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх этгээдийг бүртгэх аудит хийх журмын хэрэгжилтийн хувьд Кибер аюулгүй байдлын тухай хуульд онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагууд 2 жил тутам, дундын мэдээллийн системээр дамжуулан мэдээлэл боловсруулах, хадгалах, түгээж байгаа хуулийн этгээд жил тутам мэдээллийн аюулгүй байдлын аудит хийлгэдэг байхаар заасан. "Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх этгээдийг бүртгэх, аудит хийх журам"-ын дагуу 2025 оны 10 сарын 01-ний өдрийн байдлаар мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх зөвшөөрлийг 46 байгууллагад олгоод байна.

4. Цахим хөгжил харилцаа холбооны сайдын 2023 оны А/90 дүгээр тушаалаар баталсан Хүний эмзэг мэдээлэл, генетик болон биометрик мэдээлэл боловсруулахад баримтлах технологийн аюулгүй байдлын шаардлага, журмын хэрэгжилтийн хувьд УИХ-ын 2021 оны намрын чуулганаар баталсан "Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулга"-аар биометрик мэдээллийг хуульд зааснаас бусад зорилгоор ашиглахыг хориглосон. Мэдээлэл хариуцагч байгууллагуудад хүний эмзэг мэдээллийг боловсруулахад баримтлах технологийн шаардлагыг тодорхой болгож өгсөн.

5. Цахим хөгжил, харилцаа холбооны сайд, Тагнуулын ерөнхий газрын даргын хамтран баталсан 2024 оны А/30А/148 дугаар Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх журам, аргачлал батлах тухай тушаалын хэрэгжилтийн тухайд Кибер аюулгүй байдлын тухай хуульд онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагууд жил бүр, дундын мэдээллийн системээр дамжуулан мэдээлэл боловсруулах, хадгалах, түгээж байгаа хуулийн этгээд 2 жил тутам кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийлгэдэг байхаар заасан. Уг хуульд нийцүүлэн гаргасан "Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх этгээдийг бүртгэх, аудит хийх журам"-ын дагуу кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх зөвшөөрлийг 32 байгууллагад олгосон сайн үзүүлэлтүүд байна.

Иймд дээрх журмуудын хэрэгжилтийн явц болон 29 захиргааны актын хүрээнд хяналт-шинжилгээ хийж дараах дүгнэлтийг гаргалаа.

Гурав. Дүгнэлт

Салбарын хүрээнд баталсан захиргааны хэм хэмжээний актуудын хувьд Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлээгүй шийдвэр байхгүй. Түүнчлэн хуульд нийцүүлэхээр зарим захиргааны актын хувьд ажиллагаа хийж байна. Мөн захиргааны хэм хэмжээний актын бүртгэлийг яам дотроо хийж холбогдох нэгжүүд хэрэгжилтийг хангуулах ажиллагааг оновчтой зохион байгуулж байна гэж үзлээ.

Мөн дээрх нөхцөл байдлаас үзвэл зарим захиргааны актын хувьд цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд байсан тул эдгээр арга хэмжээг яаралтай зохион байгуулах нь зүйтэй гэж үзэж байна.

Мөн захиргааны хэм хэмжээний актын шинжийг агуулаагүй, дотоод зохион байгуулалт, зохицуулалтын шинжтэй, эсхүл ач холбогдлоо алдсан, дагаж мөрдөгдөхгүй болсон шийдвэр байхгүй гэж тайлагнасан байх боловч цаашид энэ төрлийн арга хэмжээ авах 3-4 төрлийн захиргааны акт байгааг анхаарах. Хүчигнүй болгон сангаас хасуулах арга хэмжээг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хугацааны дагуу хийж гүйцэтгэх шаардлагатай болохыг тэмдэглэж дараах зөвлөмжийг хариуцсан нэгжүүдэд хүргүүлэв.

ДӨРӨВ. ЗӨВЛӨМЖ

1. Салбарын захиргааны актыг батлуулах үйл явцыг Хууль тогтоомжийн тухай хуулийн хугацаанд нийцүүлэн зохион байгуулж хэвших;
2. Яамны газар, хэлтсүүд захиргааны актад өөрчлөлт орох тухай бүр яамны Салбарын эрх зүйн орчны шинэчлэл, хуулийн хэлтэст мэдэгдэж танилцуулах;
3. Салбарын эрх зүйн орчны шинэчлэл, хуулийн хэлтэс цаашид салбарын хуулийн хэрэгжилтийн талаар өөрт сан үүсгэж хэвших;
4. Салбарын захиргааны хэм хэмжээний актуудын цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг илүү нарийвчилсан төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх;

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны
яамны 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн
..... дугаар албан бичгийн хавсралт.

**ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙДЫН БАТАЛСАН
ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТАД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН,
ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ**
/хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй/

№	Эрх олгосон хуулийн заалт	Актын нэр	Батлагдсан шийдвэрийн		ЗХХА-ын улсын нэгдсэн санд бүртгэгдсэн		Тэмдэглэх хэсэгт үндэслэл болгосон эрх олгосон хуулийн заалтад өөрчлөлт орсон эсэх	Журмын доторх үндэслэл болгож, эшлэл хийсэн хуулийн заалт хүчинтэй эсэх	Шинээр батлагдсан холбогдох хуультай нийцсэн эсэх	Бүртгэлтэй шийдвэрт нэмэлт, өөрчлөлт оруулсан, хүчингүй болгосон тухай бүрд нь санд холбогдох хөдөлгөөн хийлгэсэн эсэх	Ач холбогдлоо алдсан, дагаж мөрдөгдөхгүй болсон шийдвэр байгаа бол хүчингүй болгон санагас хасуулах арга хэмжээ авсан эсэх	Санд бүртгүүлээгүй шийдвэр байгаа бол хуульд нийцүүлэн бүртгүүлэх арга хэмжээг авах	Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай санал	
			дугаар	огноо	огноо	дугаар								
1.Харилцаа холбооны тухай хууль														
1	6.1.4.тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үзүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох журмыг батлах	Тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үзүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох журам	ХХМТГ А/42	2017.04.17	2017.05.03	3720	үгүй	тийм	тийм	ХХМТГ-ын даргын 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/60 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсон.	-	-	Журмын 5.1-д заасан “харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны” гэсний дараа “төв” гэж нэмэх;	

2	6.1.14.а.төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллагаас үйлчилгээ үзүүлэх журам	Төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллагаас үйлчилгээ үзүүлэх журам	A/35	2022.07.06	2022.08.22	5928	үгүй	тийм	тийм	ХХМТГ-ын /хуучнаар/ даргын 2020 оны А/39 дүгээр тушаалаар батлагдсан журмыг хүчингүй болгосон.	-	-	Журмын холбогдох хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулахаар бэлтгэсэн.
2.Шуудангийн тухай хууль													
3	7.1.3. үйлчлэгч болон шуудангийн илгээмж тээвэрлэгч этгээдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах журам баталж, хэрэгжүүлэх	Шуудангаар үйлчлэгч болон шуудангийн илгээмж тээвэрлэгч этгээдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах журам	ХХМТГ А/55	2020.04.27	2020.05.12	4794	үгүй	үгүй	үгүй	Өөрчлөлт орж байгаагүй	-	-	Тус журмын зохицуулалтыг хуульд тусгаж, журмыг хүчингүй болгохоор төслийг боловсруулсан.
4	7.1.5.үнэ бүхий шуудангийн тэмдэгтийн үйлдвэрлэлт, борлуулалт, дахин үнэлэлт, улсын фондын баяжуулалт, хадгалалт, хамгаалалтын журмыг батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих;	Үнэ бүхий шуудангийн тэмдэгтийн үйлдвэрлэлт, дахин үнэлэлт, борлуулалтын журам	ХХМТГ А/54	2020.04.27	2020.05.12	4793	үгүй	тийм	тийм	Өөрчлөлт орж байгаагүй	-	-	Журмын 2.1.1.4, 2.1.1.5, 2.1.2.1-д заасан “харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны” гэсний дараа “төв” гэж нэмэх, 3.4-д заасан “шуудангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны” гэснийг “харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв” гэж өөрчлөх;
5	7.1.6.шуудангийн үйлчилгээ үзүүлэхэд мөрдөх дүрмийг батлах	Шуудангийн үйлчилгээ үзүүлэхэд мөрдөх дүрэм	ХХМТГ А/53	2020.04.27	2020.05.12	4792	үгүй	тийм	үгүй	Өөрчлөлт орж байгаагүй	-	-	Тус журмын зохицуулалтыг хуульд тусгаж, журмыг хүчингүй болгохоор

													төслийг боловсруулсан.
6	7.1.7.шуудангийн илгээмжийг түр хадгалах, задлах, хураах болон устгах журмыг батлах;	Шуудангийн илгээмжийг түр хадгалах, задлах, хураах болон устгах журам	ХХМТГ А/56	2020.04.27	2020.05.12	4795	үгүй	тийм	тийм	Өөрчлөлт орж байгаагүй	-	-	Журмын 6.3-д заасан “харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны” гэсний дараа “төв” гэж нэмэх;
7		Монгол Улсын шуудангийн нэгдсэн код	А/24	2024.09.30	2024.10.14	6950	үгүй	тийм	тийм	Өөрчлөлт орж байгаагүй	-	-	-
3.Радио долгионы тухай хууль													
8	5.2.3.радио давтамжийн зурвасыг ашиглах, төлөвлөх, дахин төлөвлөх, хуваарилах болон радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөр тогтоох журам батлах	Радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөр тогтоох журам	А/37	2022.07.22	2022.07.26	5917	үгүй	тийм	тийм	ХХМТГ-ын даргын 2020 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн А/44 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсон.	-	-	-
9	5.2.3.радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөр тогтоох журам батлах	Радио давтамжийн зурвасыг төлөвлөх, дахин төлөвлөх, хуваарилах, ашиглах журам	ХХМТГ А/48	2020.04.21	2020.05.08	4787	үгүй	үгүй	тийм	ХХМТГ-ын даргын 2020 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн А/44 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсон.	-	-	Журмын 2.1-д заасан “харилцаа холбооны асуудал хариуцсан төрийн захиргааны” гэсний дараа “төв” гэж нэмэх, 5.2-г хасах;
10	5.2.6.үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт батлах, хүснэгтэд сонгон шалгаруулалтаар олгох радио давтамжийн зурвасыг тодорхойлох;	Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт	А/46	2025.03.10	2025.04.16	7204	үгүй	тийм	тийм	ХХМТГ-ын даргын 2020 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн А/80 дугаар тушаал,	-	-	-

										Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн А/29 дугаар тушаал, 2023 оны 05 дугаар сарын 09-ны өдрийн А/42 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсон.			
11	15.3.Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийн нэгдсэн бүртгэлийн журмыг харилцаа холбооны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.	Радио давтамжийн нэгдсэн бүртгэлийн журам	А/47	2020.04.21	2020.05.08	4786	үгүй	тийм	тийм	ХХМТГ-ын даргын 2016 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/58 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсон.	-	-	Тус журмын зохицуулалтыг хуульд тусгаж, журмыг хүчингүй болгохоор төслийг боловсруулсан.
4.Өргөн нэвтрүүлгийн тухай хууль													
12	29.1.3.өргөн нэвтрүүлгийн сүлжээгээр дамжуулах гамшгийн болон онцгой байдлын талаар урьдчилан сэргийлэх үеийн мэдээ, мэдээлэл дамжуулах журам боловсруулж, батлах	Өргөн нэвтрүүлгийн сүлжээгээр гамшиг болон аюулын дохио сэрэмжлүүлгийг дамжуулах журам	А/01	2023.01.04	2023.01.16	6128	үгүй	тийм	тийм	Өөрчлөлт орж байгаагүй	-	-	-
13	29.1.5.төрийн өмчийн радио, телевизийн газрын сүлжээгээр орон даяар болон тухайн орон нутагт нь дамжуулах өргөн нэвтрүүлгийн радио, телевизийг сонгох шалгуур үзүүлэлт, тавигдах шаардлагыг батлах,	Төрийн өмчийн радио, телевизийн газрын сүлжээгээр орон даяар болон тухайн орон нутагт дамжуулах өргөн нэвтрүүлгийн радио, телевизийг сонгох шалгуур үзүүлэлт, тавигдах шаардлага	А/116	2023.11.07	2023.12.12	6493	үгүй	үгүй	тийм	Өөрчлөлт орж байгаагүй	-	-	Журмын 3.3-д заасан хуулийн эшлэлийг өөрчлөх;

	сонгон шалгаруулах, хэрэгжилтэд хяналт тавих;													
5.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль														
14	18.11.Үндсэн систем, дэмжих системийн техникийн нөхцөл, шаардлага, заавар, аргачлалыг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.	Үндсэн систем, дэмжих системийн техникийн нөхцөл, шаардлага, заавар, аргачлал	A/64	2022.10.25	2022.11.02	5988	үгүй	тийм	тийм	Өөрчлөлт орж байгаагүй	-	-	-	
15	8.18.Энэ хуулийн 8.17-д заасан зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг хууль зүйн болон цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.	Нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг зохион байгуулах, үнэлгээ хийх, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий, орон тооны бус зөвлөлийн ажиллах журам, Зөвлөлийн бүрэлдэхүүн	A-268/A-48	2022.09.19	2022.10.19	5977	үгүй	тийм	тийм	Хууль зүй, дотоод хэргийн сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын хамтарсан 2022 оны А/228/А/44 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсон.	-	-	-	
16	27.10.Цахим хэлбэрээр үүсгэх нийтийн мэдээллийн сан нь нэгдсэн ангилал, код, тайлбартай байна. 27.11.Хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 27.10-т заасан нэгдсэн ангилал, код, тайлбарыг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох мэдээлэл хариуцагчтай хамтран батална.	Статистикийн үйл ажиллагаанд хамаарах Нийтийн мэдээллийн сангийн нэгдсэн ангилал, кодын тайлбар	A-193/A-79	2022.11.18	2022.12.09	6052	үгүй	тийм	тийм	Өөрчлөлт орж байгаагүй	-	-	-	
17	29.3.энэ хуулийн 29.1, 29.2-т заасан үйл ажиллагаанд зөвлөмж, дүгнэлт гаргах журмыг цахим хөгжил, харилцаа	Мэдээлэл хариуцагч нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө үйл ажиллагаанд	A/18	2022.05.02	2022.05.17	5833	үгүй	тийм	тийм	Өөрчлөлт орж байгаагүй	-	-	Тус журмын зохицуулалтыг хуульд тусгаж, журмыг хүчингүй	

	холбооны асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн батална.	зөвлөмж, дүгнэлт гаргах журам												болгохоор төслийг боловсруулсан.
6.Кибер аюулгүй байдлын тухай хууль														
18	9.5.Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх этгээдийг бүртгэх, аудит хийх журмыг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.	Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх этгээдийг бүртгэх, аудит хийх журам	A/74	2023.08.18	2023.08.29	6384	үгүй	тийм	тийм	Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны 07 дугаар сарын 06-ний өдрийн А/65 дугаар тушаал хүчингүй болсонд тооцсон.	-	-	-	
19	13.1.5.үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий болон төрийн захиргааны төв байгууллагатай мэдээлэл солилцох, хамтран ажиллах журмыг холбогдох байгууллагатай хамтран батлах;	Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий болон төрийн захиргааны төв байгууллагатай мэдээлэл солилцох, хамтран ажиллах журам	A-57/A-76	2024.06.18	2024.07.08	6887	үгүй	тийм	тийм	Өөрчлөлт орж байгаагүй	-	-	-	
20		Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх журам, аргачлал	A30/A-148	2024.10.16	2024.11.07	6982	үгүй	тийм	тийм	Өөрчлөлт орж байгаагүй	-	-	-	
7.Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль														
21	23.3.Энэ хуулийн 23.1-д заасан үнэлгээ хийх аргачлал, журмыг Хүний эрхийн Үндэсний Комиссын саналыг үндэслэн цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.	Цахим хэлбэрээр боловсруулалт хийх технологийг ашиглан мэдээлэл цуглуулж, боловсруулж, ашиглахад үнэлгээ хийх журам	A/81	2023.09.01	2023.09.26	6429	үгүй	тийм	тийм	Өөрчлөлт орж байгаагүй	-	-	-	
22	25.1.2.хүний эмзэг мэдээлэл, генетик болон биометрик мэдээлэл боловсруулахад баримтлах технологийн аюулгүй байдлын шаардлага, журмыг батлах;	Хүний эмзэг мэдээлэл, генетик болон биометрик мэдээлэл боловсруулахад баримтлах технологийн аюулгүй байдлын шаардлага, журам	A/90	2023.09.11	2023.09.26	6432	үгүй	тийм	тийм	Өөрчлөлт орж байгаагүй	-	-	-	
8.Цахим гарын үсгийн тухай хууль														

23	16.8.Төрийн албан хаагчид гэрчилгээ олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон харилцааг зохицуулах журмыг Төрийн албаны зөвлөлийн саналыг харгалзан цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.	Төрийн албан хаагчид тооны гарын үсгийн гэрчилгээ олгох, түүнийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох журам	A/28	2022.06.23	2022.07.04	5885	үгүй	тийм	үгүй	Өөрчлөлт орж байгаагүй	-	-	Журмын 2.2, 2.3-т заасан ХУР системээс татаж шалгах боломжтой мэдээллийг хүн, хуулийн этгээдээс шаардахгүй байхаар өөрчлөлт оруулах;
24	31.1.2.нийтийн түлхүүрийг гэрчилгээжүүлэх, гэрчилгээ олгосон, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тухай мэдээллийг агуулсан гэрчилгээний үндэсний санг бүрдүүлэхтэй холбогдсон журам батлах;	Тоон гарын үсгийн гэрчилгээний үндэсний санг бүрдүүлэх, ашиглах журам	A/30	2022.06.29	2022.07.07	5896	үгүй	тийм	тийм	Өөрчлөлт орж байгаагүй	-	-	ХХЗХ-ны 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 53 дугаар тогтоолоор баталсан "Тоон гарын үсгийн гэрчилгээний мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах, хадгалах журам"-аар зохицуулсан харилцаа давхардсан байх тул эдгээр журмыг нэгтгэн батлах зохицуулалтыг хуульд тусгах;
9.Шүүх шинжилгээний тухай хууль													
25	36.4.Цахим технологийн шинжилгээ хийх журмыг хууль зүйн болон цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.	Цахим технологийн шинжилгээ хийх журам	A-315/A-91	2023.09.13	2023.09.14	6412	үгүй	тийм	тийм	Өөрчлөлт орж байгаагүй	-	-	-
10.Улсын бүртгэлийн ерөнхий хууль													
26	9.3.Улсын бүртгэлийн нэгдсэн ангилал, кодыг улсын бүртгэлийн байгууллага, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Үндэсний	Иргэний улсын бүртгэлийн үйлчилгээний ангилал, код Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн нэгдсэн ангилал, код	A-29/A-24/A-175	2021.03.18	2021.11.30	5568	үгүй	тийм	тийм	Өөрчлөлт орж байгаагүй	-	-	-

	статистикийн хороо хамтран батална.	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн нэгдсэн ангилал, код											
11.Хүүхэд хамгааллын тухай хууль													
27		Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журам	A-53/A-95/A-76	2025.03.28	2025.04.16	7204	үгүй	тийм	тийм	Өөрчлөлт орж байгаагүй	-	-	-
12.Эрүүл мэндийн тухай хууль													
28		Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний программ хангамжид тавигдах шаардлага Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний программ хангамжид үнэлгээ хийх, шаардлагад нийцсэн программ хангамжийг мэдээлэх журам	A-130/A-58	2025.04.16	2025.05.13	7241	үгүй	тийм	тийм	Өөрчлөлт орж байгаагүй	-	-	-
13.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль													
29		Аж ахуйн нэгжийн орлого олох үйл ажиллагаатай хамааралгүй, нийгмийн хариуцлагын хүрээнд харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарт хэрэгжүүлсэн орлогын албан татварын хөнгөлөлт эдлэх бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлага	A/79	2025.05.09	2025.05.21	7258	үгүй	тийм	тийм	Өөрчлөлт орж байгаагүй	-	-	-